



МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

Мэдээ-5

2014 он

Сургалтын хөтөлбөрийн талаарх нийтлэг асуулт хариулт

Дээд боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр гэж юуг хэлэх вэ?

Дээд боловсролын зэрэг олгох сургалтын үйл ажиллагаа нь тухайн чиглэлээр мэргэжсэн багш профессор, шинжээчдийн боловсруулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны баталсан хөтөлбөрийн дагуу хэрэгждэг. Сургалтын хөтөлбөр нь бакалаврын (дунджаар 120 багц цаг бүхий 4 жил үргэлжилнэ), магистрын (дунджаар 30-36 багц цаг бүхий 1.5 аас- 2 жил) болон докторын (дунджаар 60 -аас багц цагаас доошгүй, 3 аас-4 жил) зэрэг олгох хөтөлбөр гэсэн шатлалтай байна.

Хөтөлбөр нь өөр хоорондоо уялдаа холбоотой бүрэлдэхүүн хэсгүүд бүхий (хөтөлбөрийн танилцуулга, сургалтын төлөвлөгөө хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, элсэгчдэд тавих шаардлага, багшид тавих шаардлага, төгсөгчдийн эзэмших ур чадвар, суралцагчийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа хамтын ажиллагаа гм) тодорхой шатны боловсролын зэрэг (degree) олгоход чиглэсэн баримт бичиг юм.

Сургалтын хөтөлбөртэй танилцах нь оюутан танд ямар ач холбогдолтой вэ?

Оюутан сургалтын хөтөлбөртэй танилцсанаар

- Ирээдүйд сонгохоор зэхэж байгаа болон нэгэнт сонгосон мэргэжлийнхээ талаарх нарийн тодорхой мэдээлэл олж авч, ухамсартай сонголт хийх нөхцөл бүрдэнэ.
- Тухайн мэргэжлээр төгсч гараад хаана, ямар нөхцөлтэй ажиллах буюу хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил хөдөлмөр эрхлэх байгууллага, салбаруудыг мэддэг болж цаашид дадлагажих, өөрийгөө бэлдэн хөгжүүлэх боломжоор хангагдана.
- Түүнчлэн тус мэргэжлийг сонгон сурснаар таны эзэмших мэдлэг ур чадварын талаар бүрэн ойлголттой болж, хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөнд амжилттай оролцоход шаардлагатай чадавхийг эзэмшихэд өөрийгөө дайчлах, урьдчилан төлөвлөх нөхцөл бүрдэнэ.
- Тухайн хөтөлбөрт сурснаар ямар мэдлэг чадвар, туршлагатай эрдэмтэн багш нараар хичээл заалгах, ямар сонголт хийх боломжтой талаарх мэдээлэл буюу багшийн нөөц, материаллаг нөхцөл боломжийн талаар мэддэг болно.
- Мөн тус хөтөлбөр танд ямар шаардлага тавихыг мэддэг болж өөрийн чадавх чадамж, бодит нөөц боломжийг тооцон үзэх боломжтой болдог.
- Хөтөлбөр бүрийг дэлхийд эхний 100-д жагсдаг 3 -аас доошгүй их сургуулийн ижил төсөөтэй хөтөлбөрүүдтэй харьцуулан боловсруулдаг тул оюутан өөрийн мэргэжлийг гадаад улсад хэрхэн хөгжиж, ямар хандлагатай тухай мэдэх болон төгсөгчдийн олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг.

МУИС-ийн сургалтын хөтөлбөрийг хэн, хэрхэн боловсруулдаг вэ?

Сургалтын хөтөлбөрийг боловсруулах үйл явцыг "МУИС-ийн сургалтын хөтөлбөр боловсруулах түр журам" -ын дагуу зохион байгуулдаг. Хөтөлбөрийг холбогдох хөтөлбөрийн дэд хороод, хороод санаачлан боловсруулж, хэлэлцэн баталж, МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулдаг байна. Хөтөлбөрийн хороонд докторын зэрэгтэй, судалгаа, сургалтын өргөн туршлагатай, тухайн салбартаа эх орондоо болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн МУИС-ийн тэргүүний багш профессорууд ажилладаг.

МУИС-ийн захирлын 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/87 тоот тушаалаар "МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо, Ерөнхий суурь хөтөлбөрийн дэд хороо, Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн дэд хороо, Мэргэжлийн тэнхмүүдийн хөтөлбөрийн дэд хороодыг байгуулах тухай" тушаал гарч үйл ажиллагаа жигдэрсэн болно.

Өнөөдрийн байдлаар МУИС-д 21 гишүүн бүхий Хөтөлбөрийн ерөнхий хороо, 15 гишүүн бүхий Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороо, бүрэлдэхүүн сургуулийн болон тэнхмийн хөтөлбөрийн хороо гэсэн шатлал бүхий нийт 35 хороо, дэд хороо байгуулагдаж тэдгээрт докторын цол зэрэг бүхий эрдэмтэн багш нарын 90 гаруй хувийг төлөөлдөг 260 гаруй эрдэмтэн профессорууд хамрагдаж байна.

Үүний зэрэгцээ сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, онол практикийг уялдуулах үүднээс ажил олгогчдын төлөөллийг хөтөлбөрийн хороодод урьж ажиллуулж байгаа юм.

Хөтөлбөрийн бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүдийг тайлбарлана уу?

МУИС-ийн бакалаврын зэрэг олгох хөтөлбөр нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Хөтөлбөрийн ерөнхий мэдээлэл (*хөтөлбөрийн нэр, индекс, олгох боловсролын зэрэг, хөтөлбөрийн тодорхойлолт, харьяалал, эрх зүйн зохицуулалт, хөтөлбөрийн дэд хорооны нэр, холбоо барих хаяг*)
2. Хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл (*хөтөлбөрийн үндэслэл, ШУ-ны хөгжил болон хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлага, суралцагчдад тавих шаардлага, элсэгч/оюутны эрэлт хэрэгцээ, тус хөтөлбөрт сүүлийн жилүүдэд оюутны хамрагдсан байдал*)
3. Хөтөлбөрийн агуулга, багц цаг, судлах хичээлүүд (*сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, багшид тавих шаардлага, суралцах орчны шаардлага, чанарын баталгаажуулалт, хамтын ажиллагаа, харилцаа, удирдлагын систем*)
4. Хөтөлбөрийн эдийн засгийн үнэлгээ (*эдийн засгийн үр өгөөжтэй байдлын урьдчилсан тооцоо*)

Сургалтын төлөвлөгөө гэж юу болох:

Сургалтын төлөвлөгөө гэдэг нь хөтөлбөрийн нэг хэсэг бөгөөд судлах хичээлийн жагсаалт, багц цагийн багтаамж, хичээлийн төрөл, дэс дараалал, дадлага, эрдэм шинжилгээний ажлын төрөл болон зарим тайлбарыг тусгасан товчоон юм.

Хөтөлбөрийн хүрээнд судалж байгаа хичээлийг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

- ❖ *Ерөнхий суурь (General Education) хичээл.* МУИС-ийн бакалаврын сургалтад тавигдах нийтлэг шаардлагыг хангахад чиглэсэн, 1. Нийгэм хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухааны суурь мэдлэг, 2. Эзэмшсэн мэдлэг туршлагаа амьдралд бүтээлчээр бодитой ашиглах үр чадвар олгох үндсэн зорилго бүхий дээд боловсролын суурь судлагдхуун мөн.
- ❖ *Мэргэжлийн суурь (Core) хичээл.* Суралцагчид суралцах үндсэн чиглэлийнх нь шинжлэх ухааны суурь мэдлэгийг олгох, шинжлэх ухааны тухайн салбарт асуудал шийдвэрлэх, бүтээлчээр сэтгэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилготой хичээл юм.
- ❖ *Мэргэжлийн хичээл (Major course):* Тодорхой мэргэжлийн мэдлэг үр чадвар өгөхөд чиглэсэн, оюутанд шинжлэх ухаан, мэргэжлийн тодорхой чиглэл, салбараар төвлөрч, гүнзгийрэн судлах боломж олгодог хичээлүүдийг хэлнэ.
- ❖ *Заавал судлах (Compulsory) хичээл.* Тухайн хөтөлбөрийн хувьд зайлшгүй судлах шаардлагатай хичээл юм.
- ❖ *Сонгон судлах (Elective) хичээл.* Тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний бүлэг бүрээр авбал зохих багц цагийг гүйцээх зорилгоор тодорхой багц цаг бүхий хичээлийг суралцагч сонгон судлах хичээл юм.
- ❖ *Залгамж (Prerequisite) хичээл.* Тодорхой хичээлийг судлахаас өмнө амжилттай судалсан байвал зохих хичээл.
- ❖ *Зэрэгцүүлэн судлах (Corequisite) хичээл.* Тухайн хичээлтэй зэрэгцүүлэн судлах хичээл.
- ❖ *Чөлөөт сонголт (Free elective)-ын хичээл.* Суралцагч өөрийн хүсэл, сонирхлоор сонгох боломжтой МУИС-аас санал болгож байгаа бүх хичээлийг хэлнэ.

- ❖ *Онолын мэдлэг олгох хичээл.* Тухайн шинжлэх ухааны зарчим, агуулга, үндсэн ухагдахуун дээр үндэслэн мэдлэг олгох хичээл.
- ❖ *Туршилт, практик хэрэглээний хичээл.* Анги, лабораторид багшийн тусламжтайгаар суралцагч онолын мэдлэгийг бодит амьдралын үйл ажиллагаанд чиглэсэн туршилт дээр үндэслэн дадлага олгох буюу ажлын үр чадвар эзэмшүүлэх хичээл. Тус хичээл нь лаборатори доторх багаж төхөөрөмж хэрэглэх, гадаад хэлний орчуулгын дадлага хийх, лабораторийн тайлан бичих, өгөгдөлд дүн шинжилгээ хийх гэх мэт бие даалтын хэлбэрийг агуулж болно.
- ❖ *Дадлага.* Хамтарсан сургалт, сургууль байгууллага хоорондын гэрээний дагуу олгож буй дадлага, дагалдан судлах зэргээр мэргэжлийн үр чадварыг хөгжүүлэх зорилготой хичээлийн хэлбэр юм.

Хичээлийн хөтөлбөр гэж юу вэ?

Хичээлийн хөтөлбөр нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрээр суралцагчийн эзэмшвэл зохих онол, практик мэдлэг, чадварын агуулга, сэдэвчилсэн төлөвлөгөө, үнэлгээ, арга зүй, тухайн хичээлийн багтаамж/багц цаг, индекс, ашиглавал зохих ном, сурах бичиг, эх сурвалжийн жагсаалтыг тодорхойлсон баримт бичиг мөн.

Сургалтын хөтөлбөрийг оюутан суралцагчдад хэрхэн таниулан сурталчилдаг вэ?

МУИС-ийн сургалтын шинэчлэлийн дүнд Ерөнхий суурийн хичээл бүрэн чөлөөт сонголттой болсон бөгөөд мэргэжлийн хөтөлбөрт бус бүрэлдэхүүн сургуульд элсдэг болсноор өөрийн мэргэжлийг мэдээлэлтэй, ухамсартайгаар сонгох боломж нээгдэж байгаа юм. Ерөнхий суурь хичээлээс 30-аас доошгүй багц цагийг судалсны дараа цаашид суралцах үндсэн мэргэжлийн хөтөлбөрөө сонгох боломж нээгдэх бөгөөд цуглуулсан багц цаг, голч дүнгээр жагсаан ($R = \frac{\text{голч дүн}}{\text{голч дүнгийн дундач үтгэ}} * 0,5 + \frac{\text{багц цаг}}{\text{багц цагийн дундаж үтгэ}} * 0,3 + \frac{\text{судалсан хичээлийн тоо}}{\text{судалсан хичээлийн тоо}} * 0,2$) дарааллын дагуу хяналтын тоонд багтаан үндсэн мэргэжлийн хөтөлбөр сонгуулна. /Өөрчлөлт орох боломжтой/

Ерөнхий суурийн хичээл болон мэргэжил сонгоход нь оюутнуудад туслах, мэдээллээр хангах үүднээс МУИС нь а) оюутны гарын авлага, б) ерөнхий суурийн хичээлийн хэвлэмэл болон видео, электрон танилцуулга, в) шинэ оюутны чиглүүлэг танилцуулгыг зохион байгуулсан. Улмаар 2014-2015 оны намрын улиралд ерөнхий суурь болон мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулгыг их сургууль даяар зохион байгуулахаар бэлтгэлээ хангаж байна.

Товчхон: МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийг бүрэн баталсан бөгөөд эдгээр хөтөлбөрүүд нь 2015-2016 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхэлнэ. Мөн МУИС-ийн ерөнхий суурийн хичээлийн хөтөлбөрийг баталж, 2014-2015 оны хичээлийн жилийн намрын улирлаас хэрэгжүүлж байна.

МУИС-ИЙН СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБА

МУИС-ийн хичээлийн I байр,
Их Сургуулийн гудамж - 1, Бага тойруу,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар

<http://num.edu.mn>

our@num.edu.mn,